

ТАНИЛЦУУЛГА

Журам батлах тухай Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалын төсөл боловсруулсан тухай

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт “Нийгмийн даатгалын тухай хууль хүчин төгөлдөр болохоос өмнөх болон мөн үеийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр тогтоолгосон иргэдийн тэтгэврийг бодоход баримталсан хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогыг шимтгэл төлсөн хугацаа, эрхэлж байсан ажил, албан тушаал, хөдөлмөрийн нөхцөл нь ижил 1995 оноос хойш тэтгэврээ тогтоолгосон иргэний тэтгэврийг бодоход баримталсан хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын хэмжээтэй дүйцүүлэн тооцно” гэж, 30 дугаар зүйлд “Амьжиргааны өртгийн өөрчлөлттэй уялдуулан тэтгэврийн хэмжээг өөрчлөх индексийг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар тогтооно” гэж тус тус заасан.

Мөн Нийгмийн даатгалын тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай хуулийн 3² дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт заасны дагуу хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогыг дүйцүүлэн тооцох итгэлцүүрийг хэрэглээний үнийн өөрчлөлт, цалин хөлсний өсөлттэй уялдуулан Үндэсний статистикийн хороо, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар жил бүр шинэчлэн тогтооно” гэж заасан.

Дээрх хуулийн заалт, зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын 2023 оны “Итгэлцүүр шинэчлэн тогтоох, тогтоолд өөрчлөлт оруулах тухай” 238 дугаар тогтоолоор тэтгэвэр бодох цалингийн итгэлцүүрийг шинэчлэн баталж, итгэлцүүр хэрэглэх журмыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2012 оны “Журам, аргачлал батлах тухай” А/64 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр бодох цалингийн итгэлцүүрийг хэрэглэх журам”-ыг тус тус мөрдөж байна.

Улсын Их Хурлын хаврын чуулганы нэгдсэн хуралдаанаар баталсан Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 22 дугаар зүйлийн 22.3 дахь хэсэгт “Итгэлцүүрийг хэрэглэхтэй холбогдсон харилцааг зохицуулсан журмыг хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” гэж заасан.

Дээрх хуулийг хэрэгжүүлэх зорилгоор “Журам батлах тухай” Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалын болон журмын төслийг боловсруулав.

Журмын төсөлд дараах агуулгыг тусгасан болно. Үүнд:

-Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 24 дүгээр зүйлд заасан шимтгэл нөхөн төлөх харилцаанд итгэлцүүрийг хэрэглэх;

-Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-д заасан цалинд үндэслэсэн аргаар үндэслэсэн аргаар өндөр насны, хөдөлмөрийн чадвар алдсаны, тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтооход итгэлцүүрийг хэрэглэх;

-2024 онд Засгийн газрын 2023 оны “Итгэлцүүр шинэчлэн тогтоох, тогтоолд өөрчлөлт оруулах тухай” 238 дугаар тогтоолоор баталсан тэтгэвэр бодоход баримтлах итгэлцүүрийг хэрэглэх, түүнээс хойших хугацаанд Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-д заасны дагуу баталсан итгэлцүүрийг шимтгэл нөхөн төлөх, тэтгэвэр тогтооход ашиглахаар журамд тусгасан зэрэг болно.

Итгэлцүүр хэрэглэх журмын төсөлд Нийгмийн даатгалын ерөнхий газраас 2023 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн 01/2037 дугаартай албан бичгээр санал ирүүлснийг тусгасан болно.

---oOo---